



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт технологийн салбарын компаниудын хувьцааны ханш уналттай байлаа. Amazon.com компанийн ханш огцом унасанаар S&P 500 индекст багтдаг тансаг хэрэглээний бараа үйлдвэрлэгч болон эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш буурчээ. 3-р сарын 30-ны өдөр Сайн Баасан гарагийн баяр тохиож зах зээл хаалттай байв. Дотоодын аюулгүй байдлыг хангах зорилгоор Хятад улсаас АНУ-ын технологийн салбарт хийж буй хөрөнгө оруулалтыг хорих талаар АНУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газраас гаргасан мэдэгдэл технологийн салбарын хувьцааны үнийн уналтанд голчлон нөлөөлжээ. Nvidia компанийн автомат жолоодлоготой машин осол гарган явган зорчигчийн аминд хүрсэнтэй холбогдуулан тус компани технологид оруулж байсан хөрөнгө оруулалтаа түр зогсоосон хэмээн мэдэгдсэнээр 2017 онд хамгийн сайн үзүүлэлттэй байсан тус компанийн хувьцааны ханш огцом унасан.

Хятад улс АНУ-аас импортоор орж ирдэг нисэх онгоц болон шар буурцагт тариф ногдуулахгүй байхаар шийдвэрлэсэн явдалд хөрөнгө оруулагчид эерэг байр суурьтай байна. Хувьцааны зах зээлийн тогтворгүй байдал хөрөнгө оруулагчдыг ЗГҮЦ ихээр авахад хүргэсэн ба 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж 2-р сарын эхэн үеэс хойш хамгийн бага түвшинд хүрчээ.

Европ: АНУ болон БНХАУ-ын хооронд худалдааны дайн дэгдэх асуудал намжин хувьцааны ханш өсөж эхэлсэн байна. Эм зүйн салбарын Глаксо Смит Клайн компани Новатрис компанийг худалдан авч байгаа талаар мэдээлэл гарснаар тус компаниудын хувьцааны ханш өсжээ. Мөн Францын машин үйлдвэрлэгч Реналт компани Ниссантай нэгдэх талаар хэлэлцэж байгаа талаар мэдээлсэн. Түүнчлэн, Герман улсын ажилгүйдлийн түвшин 3-р сард өмнөх сарын үзүүлэлт болох 5,4%-аас буурч 5,3%-д хүрчээ. Энэ нь 1990 онд хоёр Герман нэгдсэнээс хойш тохиож буй хамгийн доод түвшин юм.

Япон: Японы хувьцааны ханш өнгөрсөн долоо хоногийн уналтаасаа сэргэн дөрвөн өдөр дарааллан өсжээ. Иений ханш чангарч Пүрэв гарагт ам. долларын эсрэг 106.44 нэгж болсон нь 2017 оны сүүлээс 5,6%-аар чангарсан үзүүлэлттэй байна. Япон улсын Либерал Ардчилсан нам 9-р сард Намын даргаа сонгох юм.

Хятад: АНУ болон Хятад улсууд сүүлд гаргасан мэдэгдлүүдээ үл харгалзан хоорондоо чимээгүй хэлэлцээр хийж, өөрсдийн худалдааны ялгаатай байдлыг шийдвэрлэхийг оролдож байна. Мөн энэ долоо хоногт Хятад улс АНУ-тай хэлэлцээр хийхэд бэлэн байгаагаа мэдээлсэн билээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	21,021.83	-2.14 ▼
Dow Jones	АНУ	24,103.11	2.42% ▲
S&P 500	АНУ	2,640.87	2.03% ▲
Nasdaq	АНУ	7,063.44	1.01% ▲
S&P/TSX	Канад	15,367.29	0.94% ▲
FTSE 100	Их Британи	7,056.61	1.95% ▲
S&P/ASX 200	Австрали	5,759.40	-1.05% ▼
Nikkei 225	Япон	21,454.30	4.06% ▲
Hang Seng	Хонг Конг	30,093.38	-0.71% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	112.61
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	98.92
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	97.98
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	115.33
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.33
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.83
TDBM' 2020	USD	9.3%	107.72

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	ҮөҮ
Libor 1M	1.883	0.0 ▲
Libor 3M	2.312	0.02 ▲
Libor 6M	2.452	0.00 ▲
Libor 1YR	2.663	0.00 ▼
US 6M Bond	1.906	0.01 ▲
US 2YR Bond	2.282	0.01 ▲
US 3YR Bond	2.405	-0.01 ▼
US 5YR Bond	2.589	-0.02 ▼
US 10YR Bond	2.766	-0.06 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.03.30	Өөрчлөлт
USD	2,392.77	-0.15% ▼
CNY	381.39	0.71% ▲
EUR	2,498.25	-15.40% ▼
RUB	41.74	-0.50% ▼
KRW	2.25	1.35% ▲
JPY	22.53	-1.27% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,325.47	-1.62% ▼
Мөнгө /spot/	16.37	-1.21% ▼
Зэс	302.55	1.09% ▲
Нүүрс	91.20	0.86% ▲
WTI газрын тос	64.94	-1.43% ▼
Brent газрын тос	69.34	-1.58% ▼
Байгалийн хий	2.73	5.41% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляций түвшин	2018.II	6.90%
Бодлогын хүү	2018.II	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.II	11.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.II	12.90%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.II	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.II	19.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.II	11.50%

Эх сурвалж: Үндэсний статистикий хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 54 компанийн 3,953 сая төгрөгийн 11,054,316 ширхэг хувьцаа арилжигдав.

“Түшиг Уул” /TUS/ компанийн хувьцаа 25.28%-аар буюу хамгийн ихээр өсч 550 төгрөгт хүрч хаагдсан бол “Авто зам” /AAR/ компанийн хувьцаа 17.97%-аар буурч 4,100 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээлд арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 4 удаагийн хэлцлээр 4,021 ширхэг үнэт цаас 402.2 сая төгрөгөөр арилжаалагдлаа.

Харин компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр энэ долоо хоногт арилжаа хийгдээгүй байна.


3-р сарын 30-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,587.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 21,021.83 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 2.14%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	4,355.2
Зах зээлийн үнэлгээ	2,587,278.8

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	21,021.83	-2.14% ▼
MSE I индекс	10,452.17	-4.40% ▼
MSE II индекс	10,115.29	-0.46% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Дархан нэхий	168,372	3,099,728,000
ЛэндМН ББСБ	9,809,110	417,659,518
Тавант Толгой	12,919	154,687,680
АПУ	181,442	118,402,858
Говь	1,638	38,624,300

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Түшиг Уул	550.00	25.28% ▲
Бүтээлч үйлс	1,449.00	15.00% ▲
Евроазиа Капитал Холдинг	767.91	15.00% ▲
Техник импорт	20,700.00	15.00% ▲
Могойн гол	7,995.00	14.21% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Авто зам	4,100.00	-17.97% ▼
Сор	1,450.00	-14.61% ▼
Хархорин	1,500.00	-14.29% ▼
Фронттиер лэнд групп	301.00	-12.75% ▼
Ар Баянхангай	800.00	-11.11% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Дэлгэрхангай секьюритиз	6,048,817,015
Голомт Капитал	241,939,668
Ти Ди Би Капитал	228,295,247
БиДиСек	218,314,648
Мирэ Эссет Секьюритис Монгол	217,451,764

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	647.39	688,940
Таван толгой	11,580.00	609,863
МИК	11,290.00	233,808
Говь	23,480.00	183,170
Сүү	230.87	79,419

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZBEG-BD-04/07/19-A0266-14.82	230	23,082,800	100,720	100,000	104	14.820
2	ZBEG-BD-16/10/20-A0342-13.91	3,698	369,800,000	100,000	100,000	156	13.910
3	ZBEG-BD-18/07/20-A0275-15.14	93	9,393,000	101,000	100,000	156	15.140

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Нийт ногдол ашиг /сая төг/	Нэгж хувьцаанд ногдох ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	TTL	Таван Толгой	ХЭХ-аар тогтооно		2018.03.16	2018.04.03	N/A
2	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	587.7	56.6	2018.03.07	2018.03.27	2018.07.02-оос
3	AEL	Анд-Энерги ХК	13.3	0.5	2018.02.24	2018.03.16	N/A
4	SUL	Жуулчин дүти фрий ХК	653.6	10,000.0	2018.02.23	2018.04.11	2018.05.01-ээс
5	SUU	Сүү ХК	1,032.0	3.0	2018.02.14	2018.04.05	2018.12.31-ний дотор
6	GTL	Гутал ХК	2,055.7	1,270.0	2018.02.19	2018.03.18	2018.07.06-аас
7	BNG	Баянгол Зочид буудал ХК	150.2	355.0	2018.02.19	2018.04.06	2018.09.01-ээс
8	APU	АПУ ХК	10,641.8	10.0	2018.02.19	2018.03.29	2018.06.01-ний дотор
9	BTG	Баянтээг ХК	25.3	100.0	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
10	MIE	Материалимпекс ХК	13.7	10.0	2018.02.19	2018.03.26	2018.12.31-ний дотор
11	MNP	Монгол шуудан ХК	367.2	3.6	2018.02.13	2018.04.13	2018.05.01-ээс
12	MMX	Махимпекс ХК	380.1	100.0	2018.02.13	2018.04.05	2018.10.01-ээс
13	TCK	Талх чихэр ХК	174.0	170.0	2018.02.12	2018.04.06	2018.07.01-ээс
14	ADL	Адуун чулуун ХК	409.6	130.0	2018.01.24	2018.03.01	N/A
15	UBH	Улаанбаатар хивс ХК	40.4	100.0	2018.02.05	2018.02.26	2018.05.01-ний дотор
16	TAH	Тахь-ко ХК	128.5	108.0	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
17	GOV	Говь ХК	1,716.2	220.0	2018.02.02	2018.03.27	2018.04.24-өөс
18	HRM	Гермес Центр ХК	392.7	5.0	2018.01.24	2018.02.15	2018.03.06-аас

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Хурлын төрөл	Бүртгэлийн өдөр	Хуралдах өдөр	Хуралдах цаг
1	BTG	Баянтээг ХК	Ээлжит	2018.03.12	2018.04.02	10:00
2	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	Ээлжит	2018.03.12	2018.04.02	11:00
3	BHL	Бөөний худалдаа ХК	Ээлжит	2018.03.05	2018.04.04	13:00
4	AZH	Алтайн зам ХК	Ээлжит	2018.03.01	2018.04.04	16:00
5	HRD	Хүрд ХК	Ээлжит	2018.02.23	2018.04.04	16:00
6	HBT	Хөнгөн Бетон ХК	Ээлжит	2018.03.13	2018.04.04	17:00
7	MNB	Мон Наб ХК	Ээлжит	2018.03.14	2018.04.05	14:00
8	SSG	Сонсголон бармат ХК	Ээлжит	2018.03.09	2018.04.06	10:00
9	GHC	Ган хийц ХК	Ээлжит	2018.03.06	2018.04.06	11:00
10	DAZ	Дорнод авто зам ХК	Ээлжит	2018.03.12	2018.04.09	15:00
11	GTL	Гутал ХК	Ээлжит	2018.03.18	2018.04.09	15:00
12	HUZ	Хөвсгөл усан зам ХК	Ээлжит	2018.02.26	2018.04.09	-
13	UBH	Улаанбаатар хивс ХК	Ээлжит	2018.02.26	2018.04.10	11:00
14	OLL	Оллоо ХК	Ээлжит	2018.03.19	2018.04.10	14:00
15	ALI	Стандарт Ноос ХК	Ээлжит	2018.02.26	2018.04.10	15:00
16	HRL	Хэрлэн хивс ХК	Ээлжит бус	2018.03.19	2018.04.10	-
17	ETR	Э-Транс ложистикс ХК	Ээлжит	2018.03.23	2018.04.11	10:00
18	HUN	Увс хүнс ХК	Ээлжит	2018.03.23	2018.04.13	9:00
19	BRC	Барилга Корпораци ХК	Ээлжит	2018.03.16	2018.04.14	10:00

№	Симбол	Компанийн нэр	Хурлын төрөл	Бүртгэлийн өдөр	Хуралдах өдөр	Хуралдах цаг
20	DBL	Даваанбулаг ХК	Ээлжит	2018.03.24	2018.04.14	14:00
21	HTS	Хөтөлийн цемент шохой ХК	Ээлжит бус	2018.03.28	2018.04.16	10:00
22	TEX	Техник импорт ХК	Ээлжит	2018.03.28	2018.04.16	15:00
23	HUV	Хөвсгөл геологи ХК	Ээлжит	2018.03.29	2018.04.17	10:00
24	GOV	Говь ХК	Ээлжит	2018.03.27	2018.04.17	14:00
25	HVL	Хөвсгөл ХК	Ээлжит	2018.03.28	2018.04.17	14:00
26	HNS	Хөвсгөл хүнс ХК	Ээлжит	2018.03.28	2018.04.17	17:00
27	TGS	Номин Хишиг ХК	Ээлжит	2018.03.29	2018.04.18	10:00
28	SOR	Сор ХК	Ээлжит	2018.03.28	2018.04.18	10:00
29	ARH	Сэлэнгэ Ар Хөвч ХК	Ээлжит	2018.03.30	2018.04.18	14:00
30	HHN	Хархорин ХК	Ээлжит	2018.03.30	2018.04.18	14:00
31	MIE	Материалимпэкс ХК	Ээлжит	2018.03.26	2018.04.20	10:30
32	TAV	Тав ХК	Ээлжит	2018.03.28	2018.04.20	11:00
33	APU	АПУ ХК	Ээлжит	2018.03.29	2018.04.20	15:00
34	NOG	Ачит Алкабы ХК	Ээлжит	2018.03.27	2018.04.20	15:00
35	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	Ээлжит	2018.03.27	2018.04.20	16:00
36	HSG	Хөсөг трейд ХК	Ээлжит	2018.03.23	2018.04.21	12:00
37	AEL	Анд-Энерги ХК	Ээлжит	2018.03.16	2018.04.21	12:00
38	CHR	Увс Чацаргана ХК	Ээлжит	2018.03.23	2018.04.22	11:00
39	BNB	Баялаг Налайх ХК	Ээлжит	2018.03.30	2018.04.22	15:00
40	BDS	Би Ди Сек ХК	Ээлжит	2018.04.02	2018.04.23	10:00
41	SDT	Хот девелопмент ХК	Ээлжит	2018.04.03	2018.04.23	10:00
42	BEU	Бэрх Уул ХК	Ээлжит	2018.04.03	2018.04.23	12:00
43	MNS	Монноос ХК	Ээлжит	2018.03.31	2018.04.23	15:00
44	UYN	Монгол савхи ХК	Ээлжит	2018.04.05	2018.04.24	10:00
45	JGV	Жуулчин говь ХК	Ээлжит	2018.04.05	2018.04.24	13:00
46	MNG	Мандал говь импекс ХК	Ээлжит	2018.04.05	2018.04.24	15:00
47	BHG	Бөхөг ХК	Ээлжит	2018.03.23	2018.04.25	10:00
48	TAH	Тахь-ко ХК	Ээлжит	2018.03.30	2018.04.25	10:00
49	BBD	Стандарт проперти групп ХК	Ээлжит	2018.04.10	2018.04.25	11:00
50	BUK	УБ-БҮК ХК	Ээлжит	2018.04.03	2018.04.25	11:00
51	BDL	Могойн гол ХК	Ээлжит	2018.04.04	2018.04.25	12:00
52	EER	Ариг гал ХК	Ээлжит	2018.04.02	2018.04.25	17:00
53	HJL	Орхон хөгжил ХК	Ээлжит	2018.04.03	2018.04.25	-
54	MMX	Махимпекс ХК	Ээлжит	2018.04.05	2018.04.26	14:00
55	TTL	Таван Толгой ХК	Ээлжит	2018.04.03	2018.04.26	14:00
56	SHG	Шарын гол ХК	Ээлжит	2018.04.02	2018.04.26	15:30
57	BNG	Баянгол зочид буудал ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.26	16:00
58	MBG	Мон-Ит Булигаар Хк	Ээлжит	2018.04.05	2018.04.27	9:00
59	JTB	Женко Тур Бюро	Ээлжит	2018.04.04	2018.04.27	10:00
60	UID	Улсын их дэлгүүр ХК	Ээлжит	2018.03.30	2018.04.27	10:00
61	BUN	Булган ундрага ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.27	11:00
62	ERS	Монгол алт ХК	Ээлжит	2018.04.05	2018.04.27	11:00
63	MNH	Монгол Нэхмэл ХК	Ээлжит	2018.03.30	2018.04.27	11:00
64	MIB	Монинжбар ХК	Ээлжит	2018.03.20	2018.04.27	11:00
65	CHE	Хорго Хайрхан ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.27	11:00
66	SUN	Евроазиа капитал холдинг ХК	Ээлжит	2018.03.20	2018.04.27	12:00
67	BOE	Эрчим баян өлгий ХК	Ээлжит	2018.04.05	2018.04.27	12:00
68	ALD	Азык ХК	Ээлжит	2018.03.28	2018.04.27	14:00
69	ATR	Атар-Өргөө ХК	Ээлжит	2018.04.10	2018.04.27	14:00
70	DZG	Дархан зочид буудал ХК	Ээлжит	2018.03.28	2018.04.27	14:00

№	Симбол	Компанийн нэр	Хурлын төрөл	Бүртгэлийн өдөр	Хуралдах өдөр	Хуралдах цаг
71	GFG	Силк нэт ХК	Ээлжит	2018.03.20	2018.04.27	14:00
72	TCK	Талх Чихэр ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.27	14:00
73	TEE	Тээвэр дархан ХК	Ээлжит	2018.04.05	2018.04.27	14:00
74	MRX	Мерекс ХК	Ээлжит	2018.04.07	2018.04.28	10:00
75	ECV	Эрээнцав ХК	Ээлжит	2018.04.09	2018.04.28	11:00
76	AMT	Хар хорум пропертийс ХК	Ээлжит	2018.04.09	2018.04.28	12:00
77	MBG	Жинст-Увс ХК	Ээлжит	2018.04.12	2018.04.28	14:00
78	JLT	Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК	Ээлжит	2018.03.22	2018.04.28	14:00
79	TUS	Түшиг Уул ХК	Ээлжит	2018.03.29	2018.04.28	14:00
80	MOG	Монгео ХК	Ээлжит	2018.04.09	2018.04.29	9:00
81	HCH	Е-Моние ХК	Ээлжит	2018.04.08	2018.04.29	11:00
82	HBZ	Хүннү менежмент ХК	Ээлжит	2018.04.08	2018.04.29	11:00
83	DAR	Дархан гурил тэжээл ХК	Ээлжит	2018.04.10	2018.04.29	13:00
84	DOT	Дорнод тээвэр ХК	Ээлжит	2018.04.08	2018.04.29	14:00
85	TVT	Хар тарвагатай ХК	Ээлжит	2018.04.09	2018.04.29	15:00
86	HSR	Хасу-Мандал ХК	Ээлжит	2018.03.23	2018.04.29	15:00
87	SUL	Жуулчин дюти фрии ХК	Ээлжит	2018.04.11	2018.04.30	-
88	DMA	Дэвшил Мандал ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.30	9:00
89	NXE	Нэхээсгүй эдлэл ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.30	9:00
90	ALA	Алтайн Нэгдэл ХК	Ээлжит	2018.03.30	2018.04.30	10:00
91	BAZ	Люкс канаду групп ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.30	10:00
92	MIK	МИК Холдинг ХК	Ээлжит	2018.04.11	2018.04.30	10:00
93	MNP	Монгол шуудан ХК	Ээлжит	2018.04.13	2018.04.30	10:00
94	TMZ	Төмрийн завод ХК	Ээлжит	2018.04.09	2018.04.30	10:00
95	NRS	Шинэст ХК	Ээлжит	2018.04.10	2018.04.30	10:00
96	BAN	Багануур ХК	Ээлжит	2018.04.13	2018.04.30	11:00
97	GTJ	Булган гурил тэжээл ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.30	11:00
98	BLC	Бүтээлч үйлс ХК	Ээлжит	2018.04.05	2018.04.30	11:00
99	JGL	Говийн өндөр ХК	Ээлжит	2018.04.09	2018.04.30	11:00
100	MCH	Монголын цахилгаан холбоо ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.30	11:00
101	RMC	Ремикон ХК	Ээлжит	2018.04.12	2018.04.30	11:00
102	SOH	Уужим Хангай ХК	Ээлжит	2018.04.12	2018.04.30	11:00
103	EAZ	Эрдэнэт авто зам ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.30	11:00
104	NKT	Нако Түлш ХК	Ээлжит	2018.04.03	2018.04.30	12:00
105	АНН	Хорин хоёрдугаар бааз ХК	Ээлжит	2018.03.23	2018.04.30	13:00
106	HZB	Ган хэрлэн ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.30	14:00
107	INT	Ингэттолгой ХК	Ээлжит	2018.04.09	2018.04.30	14:00
108	MSH	Монгол шилтгээн ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.30	14:00
109	HBO	Хай би ойл ХК	Ээлжит	2018.04.10	2018.04.30	14:00
110	HGN	Хөх ган ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.30	14:00
111	SHV	Шивээ овоо ХК	Ээлжит	2018.04.05	2018.04.30	14:00
112	JRG	Эвлэл ХК	Ээлжит	2018.04.09	2018.04.30	14:00
113	TAS	Эрдэнэт хүнс ХК	Ээлжит	2018.03.31	2018.04.30	14:00
114	ITLS	Айтүүлс ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.30	15:00
115	GUR	Гурил ХК	Ээлжит	2018.04.07	2018.04.30	15:00
116	SUU	Сүү ХК	Ээлжит	2018.04.05	2018.04.30	15:00
117	MDR	Фронтиер лэнд групп ХК	Ээлжит	2018.04.06	2018.04.30	15:00
118	HAM	Монголын хөгжил үндэсний нэгдэл ХК	Ээлжит	2018.04.09	2018.04.30	17:00
119	BSKY	Блюскай секьюритиз	Ээлжит	2018.03.30	2018.04.30	18:00
120	ONH	Өндөрхаан ХК	Ээлжит	2018.04.12	2018.04.30	13:00
121	LND	ЛендМН ББСБ ХК	Ээлжит бус	2018.04.11	2018.05.10	18:00

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Монгол шуудан” ХК ногдол ашгийн хэмжээгээ нэмэгдүүллээ

“Монгол Шуудан” ХК-ийн 2017 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлангаар цэвэр ашгийн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн №18/04 тоот тогтоолоор компанийн цэвэр ашгийн 30 хувь буюу нэгж хувьцаанд 3.68 төгрөг, нийт 367,247,033 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож, 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “ҮЦТХТ” ТӨХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 18/01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсон байна.

Эх сурвалж: MSE.mn



Хөрөнгө оруулагчид онлайнаар арилжаанд оролцохтой холбогдох тодруулга

МХБ-ийн гишүүн үнэт цаасны компаниуд нь холбогдох журмын дагуу харилцагчдын захиалгыг утсаар, биечлэн, цахим шуудангаар болон өөрсдийн хөгжүүлсэн системийг ашиглан хүлээн авдаг.

МХБ-д одоогоор 58 гишүүн үнэт цаасны компани бүртгэлтэй бөгөөд тэдгээрээс цөөн тооны компаниуд нь харилцагчдыг алсаас арилжаанд оролцох боломжоор хангаад байна. Эдгээр компаниуд нь харилцагчдын захиалгыг өөрсдийн хөгжүүлсэн дотоод системээрээ дамжуулан МХБ-ийн арилжааны системд шууд оруулдаг бөгөөд системийн хэвийн ажиллагаа хангагдаж байгаа тохиолдолд хоцрогдол үүсэхгүй байх зарчимтай болно.

Харин зарим гишүүн үнэт цаасны компаниуд нь өөрийн хөгжүүлсэн дотоод системээр дамжуулан харилцагчдын захиалгыг онлайнаар хүлээн авдаг боловч тус дотоод систем нь МХБ-ийн Милленниум Ай Ти системд шууд холбогдоогүйн улмаас онлайнаар хүлээн авсан захиалгуудыг өөрийн дотоод системээс МХБ-ийн арилжааны системд гар аргаар шивж оруулдаг нь хугацааны хувьд илүү хоцрогдол үүсэх нөхцөл болдог.

Иймд хөрөнгө оруулагчид та бүхэн үйлчлүүлж буй үнэт цаасны гишүүн компаниуддаа захиалгаа онлайнаар өгч байгаа тохиолдолд, тус компанийн захиалга авах систем нь МХБ-ийн арилжааны системд шууд холбогддог эсэх, хэдий хугацааны хоцрогдол үүсдэг зэргийг тодруулахыг зөвлөж байна.

Эх сурвалж: MSE.mn

“Лэндмн ББСБ” ХК-ийн зээлийн хүүгийн орлого 143 дахин өсөв

“Лэндмн ББСБ” хувьцаат компани 23.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Өмнө нь 2016 онд 7.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан юм. Тус компанийн зээлийн хүүгийн орлого 2017 онд 143 дахин өссөнөөр 961.7 сая төгрөгт хүрчээ. Хөрөнгийн зах зээлийн “отгон тоглогч” болох “Лэндмн ББСБ” компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал тавдугаар сарын 10-ны өдөр болох товтой байна. Харин хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг ирэх сарын 11-нээс өмнө бүртгэх ажээ. Хурлаар компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгож, санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлангаа танилцуулна. Үүнээс гадна “Лэндмн ББСБ” компани өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг хэлэлцэхээр товлосон байна.

Тус компанийн хувьцааны ханш 57.8 төгрөгт хүрч өсөж байсан ч сүүлийн байдлаар 46 төгрөг боллоо. Олон нийтэд хувьцаагаа арилжиж эхэлснээс хойш хоёр долоо хоног гаруйн хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд “Лэндмн ББСБ”-ийн хувьцааны арилжаа нийт 2.1 тэрбум төгрөгөөр хийгджээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Говь” компани борлуулалтын орлогоо 21 хувиар нэмэгдүүлнэ

180 гаруй тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй “Говь” компани энэ онд борлуулалтын орлогоо өмнөх оноос 21 хувиар нэмэгдүүлж, 150.4 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөсөн байна. 2017 онд дотоод борлуулалт өмнөх оноос 38 хувиар өсөж, 74.6 тэрбум төгрөгт хүрсэн талаар тус компани мэдээллээ. Дотоод борлуулалтын 49 хувийг монгол худалдан авагчид, 51 хувийг гадаад худалдан авагчид буюу жуулчдын худалдан авалт бүрдүүлсэн байна. “Говь” хувьцаат компаниас худалдан авалт хийсэн жуулчдын 67 хувийг БНСУ болон БНХАУ-ын жуулчид эзэлжээ.

Харин салбар болон франчайз дэлгүүрүүдийн борлуулалт буюу гадаад борлуулалт нь 44 хувиар өссөнөөр 49.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2017 оны сүүлийн байдлаар 13 орны 34 хотод 50 франчайз дэлгүүр, таван салбар дэлгүүртэй үйл ажиллагаагаа явуулж байгаа ажээ. 2022 он гэхэд гадаад дахь дэлгүүрийн тоог 100-д хүргэж 80 франчайз дэлгүүр, 20 салбар дэлгүүртэй болохоор зорьж байгаа талаараа мэдээллээ.

Үүнээс гадна “Говь”-ийн экспортын орлого 20.4 сая ам.долларт хүрсэн байна. Тус компанийн хувьцааны ханш сүүлийн нэг жилийн хугацаанд хоёр дахин өсөж, 23 мянган нэгжийг даваад байгаа аж. “Говь” компани олон нийтэд нээлттэй болсон цагаас хойш 15 удаа ногдол ашгаа тарааж байсан юм. Мөн энэ онд 2017 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 220 төгрөг буюу нийт 1.7 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ олгохоор болжээ.

Хувьцаат компаниуд тавдугаар сарын нэгнээс өмнө Хувьцаа эзэмшигчдийн хурлаа зарлаж, хуралдуулах үүрэгтэй байдаг. Үүний дагуу “Говь” компани дөрөвдүгээр сарын 17-нд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хийхээр товлосон байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Southgobi Resources”-ийн борлуулалтын орлого 2 дахин өсөж, 121 сая ам.долларт хүрэв

Торонто, Хонгконгийн Хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй “Southgobi Resources” компанийн 2017 оны борлуулалтын орлого жилийн дүнгээр бараг хоёр дахин өсөж, 121 сая ам.долларт хүрлээ. 2017 онд нүүрсний ханш 79 хувиар өсөж, нэг тонн нь 28 ам.долларт хүрсэн болон нүүрсний олборлолт нь 19 хувиар нэмэгдсэн нь тус компанийн санхүүгийн үзүүлэлт сайжрахад голчлон нөлөөлсөн байна. Тухайлбал, 2017 онд “Southgobi Resources” компанийн алдагдал 152 хувиар буурч, 40 сая ам.долларт хүрчээ. Өнгөрсөн онд тус компани БНХАУ-ын “CIC” компанид 2017 оны 11 дүгээр сарын хөрвөх бондын хүүгийн төлөлттэй холбоотой 21.8 сая ам.долларын төлбөрөө хийгээгүй байна. Өрийн эргэн төлөлтийг хойшлуулах талаар “CIC” компанитай тохиролцоонд хүрэхээр хичээж байгаагаа тус компани тайландаа тусгажээ. “Southgobi Resources” компани SSCC стандартын өндөр чанартай, коксжих нүүрс үйлдвэрлэж, ашгаа нэмэгдүүлэх зорилгоор 2017 онд нүүрс угаах үйлдвэр амжилттай барьсан байна. Шинэ үйлдвэр энэ оны хоёрдугаар хагаст ашиглалтад орох товтой байгаа аж. 2018 оны гуравдугаар сарын 28-ны байдлаар “Southgobi Resources” компани 7.1 сая ам.долларын бэлэн мөнгө эзэмшиж байгаа ажээ.

Торонтогийн Хөрөнгийн биржид тус компанийн хувьцааны ханш он гарснаас хойш 10.8 хувиар унаад байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



“Erdene Resource Development”-ийн цэвэр алдагдал 2017 онд 61 хувиар өсжээ

Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Erdene Resource Development” компанийн цэвэр алдагдал 2017 онд 61 хувиар нэмэгдэж, дөрвөн сая канад долларт хүрсэн байна. “Erdene Resource Development”-ийн байгууллагын болон удирдлагын зардал нь 69 орчим хувиар нэмэгдсэн нь үйл ажиллагааных нь алдагдал нэмэгдэхэд ихээхэн нөлөөлсөн байна. Тус компани 2017 оны хайгуулын ажилд 1.6 сая канад доллар зарцуулсан бөгөөд энэ нь жилийн дүнгээр 33 орчим хувиар буурсан үзүүлэлт болжээ. “Erdene Resource Development” компани “Баян хөндий”, “Алтан арроу” төслийн хайгуулын ажилд голчлон анхаарч, зургаан сая канад долларын нэмэлт хөрөнгө оруулалт хийсэн байна. Харин “Цэнхэр номин” төсөлдөө 1.5 сая канад долларын нэмэлт санхүүжилт зарцуулжээ. “Erdene Resource Development” компани тайлант жилд 13 орчим сая канад долларын шинэ хувьцаа гаргаж, нэмэлт хөрөнгө оруулалт татсан байна. Тус компанийн хувьцааны ханш Торонтогийн Хөрөнгийн биржид он гарснаас хойш 29.6 хувиар буурчээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



“Rio Tinto” нүүрсний бизнесээс гарав

“Rio Tinto” компани долоо хоногийн дотор дөрвөн тэрбум ам.долларын хэлцэл хийснээр нүүрсний бизнесээсээ бүрмөсөн гарч байна. Тус компани “Kestrel” нүүрсний ордын эзэмшлээ “EMR Capital” болон Индонезийн “Adaro Energy” компаниудад 2.25 тэрбум ам.доллараар худалдахаа мягмар гарагт мэдээллээ. Үүнээс өмнө Австрали дахь нүүрсний гурван ордоо 1.9 тэрбум ам.доллараар худалджээ. Нүүрс олборлолтоор дэлхийд тэргүүлэгчдийн нэг “Rio Tinto” групп нүүрсний бизнесээс гарч төмрийн хүдэр, хөнгөн цагааны бизнесээ өргөжүүлэх зорилт тавин ажиллаж байгааг тус компанийн захирал Жан-Себастьян Жак мэдэгдэж байсан юм. 10 жилийн өмнө “Rio Tinto”-ийн нийт орлогын 25 орчим хувийг нүүрс, ураны бизнес бүрдүүлдэг байсан бол 2017 онд ердөө долоон хувь болж буурсан байна. Хэдий тийм боловч уул уурхайн бусад томоохон компаниуд үүнээс өөр бодлого баримталж байгаа аж. Тухайлбал, “Anglo American” компани нүүрсний зарим ордуудаа худалдах төлөвлөгөөгөө хойшлуулсан бол нүүрс нийлүүлэлтээрээ дэлхийд тэргүүлэгч “Glencore” компани бизнесээ тэлэхээр худалдан авах хэлцлээ эрчимжүүлээд байна.

Харин нөгөө талаас хөрөнгө оруулагч нар байгальд ээлтэй сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих алхмуудыг хийж эхэлжээ. Норвегийн Баялгийн сан нийт борлуулалтын 30 хувийг нүүрснээс бүрдүүлдэг компаниудад хөрөнгө оруулахгүй гэдгээ мэдэгдээд байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

МАК: Уурхайн аман дээр тонн нүүрсийг 500 юаниар борлуулж байна

2018 онд 10 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөж байгаа “Эрдэнэс Тавантолгой” ХК “Chalco”-тай үнээ шинэчлэн тохирч чадаагүй байна. Гуравдугаар сарын байдлаар нэг тонн нүүрсийг уурхайн аман дээр 68.1 ам.доллараар борлуулж байгаа гэдгийг тус компанийн Гүйцэтгэх захирал Д.Ариунболд мэдээллээ. Нарийнсухайтын бүлэг ордод МАК буюу “Монголын алт корпораци”, “SouthGobi Sands”, “Өсөх зоос” компаниуд олборлолт хийж байгаа юм. “Монголын алт корпораци” 2018 он гарснаас хойш 1.5 сая тонн нүүрс экспортлоод байна. Ингэхдээ нэг тонн нүүрсийг уурхайн аман дээр 500 орчим юаниар борлуулж байгаа талаар МАК-ийн тэргүүн дэд Ерөнхийлөгч Г.Цогт мэдээллээ. Нарийнсухайтын нүүрсний гуравны нэг нь коксждог, бусад хэсэг нь эрчим хүчний нүүрсэнд тооцогдож байгаа юм.

Харин “SouthGobi Sands” ХХК-ийн хувьд 2017 онд нэг тонн нүүрсний дундаж ханш 280 юань байжээ. Энэ онд 5.5 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөснөөс 800 мянган тонныг нь баяжуулж гаргана. Баяжуулсан нүүрсний ханш тонн тутамдаа 500-600 юаньд хүрнэ гэж тус компани тооцоолж байна.

2017 оны аравдугаар сард “Нүүрстэй” коксжих нүүрсний ордын олборлолтын тусгай зөвшөөрлийг аваад байгаа “Aspire Mining” компанийн хувьд коксжих нүүрсний ханш цаашид тогтвортой байна гэж харж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



“Эрдэнэс Тавантолгой” Хөгжлийн банкинд өрөө төлж, ашигт ажиллагаа руу шилжив

2017 оны хувьд нүүрс, зэсийн үнэ дэлхийн зах зээл дээр өсч, монголын эдийн засаг тэр дундаа уул уурхайн салбарын өсөлтөд жин дарсан.

Тодруулбал экспортын 78.8 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж буй бөгөөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 1.4 тэрбум ам. доллар, үүнээс нүүрсний экспорт 1.3 тэрбум ам.доллараар тэлсэн нь эдийн засгийн үзүүлэлтүүдийг өсгөв. Дэлхийн зах зээл дээр нүүрс, зэсийн үнэ энэ хэвээр үргэлжилбэл манай улсын хувьд эдийн засагт гарсан эерэг үзүүлэлтүүдээ бататгана гэсэн хүлээлт байна.

Энэхүү эерэг үзүүлэлтэд 600-гаад уурхайчинтай “Эрдэнэс Тавантолгой” компани ямар хувь нэмэр оруулсныг тоон баримтаар үзүүлье.

Тус компани цанхийн баруун, зүүн уурхай эксковатор, автосамосвалын хослол бүхий, гадаад овоолготой ашиглалтын системээр батлагдсан техник эдийн засгийн үндэслэл, уулын ажлын төлөвлөгөөний дагуу олборлолтын ажлыг гүйцэтгэдэг байна. “Эрдэнэс-Таван толгой” ХК 2016 онтой харьцуулбал борлуулалтын хэмжээ өнгөрсөн онд 13 хувиар өсч, орлого 2.5 дахин буюу 153 хувиар өсчээ. Өмнөх дөрвөн жилд дараалан алдагдалтай ажилласан тус компани өнгөрсөн онд анх удаа өндөр ашигтай ажиллаж цэвэр ашгийн хэмжээг 636 тэрбум төгрөгөөр өсч, улсад төвлөрүүлсэн татвар, хураамжийн дүн 3.4 дахин өссөн байна. Тус компани үүсгэн байгуулагдсанаасаа хойш нийт 485 тэрбум төгрөгийг татвар хураамжид төлжээ. Үүний тал хувийг 5 жилийн хугацаанд төлсөн бол 2017 оны эхний гурван улирлын байдлаар 230 тэрбум төгрөгийн татвар төвлөрүүлж, өөрийн ашиг нь 340 тэрбум төгрөгөөр хэмжигдэв. 2018 онд тус компани 10 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөжээ.

Өнгөрсөн хугацаанд тус компани амжилттай ажилласан нь нүүрсний ханшийн өсөлт болон БНХАУ-ын Чалко компанийн өрийг 100 хувь барагдуулсантай холбоотой аж. Тодруулбал “Чалко” компаниас 2011 онд 250 сая ам.доллар, 2012 онд 100 сая ам.доллар авч, нийт 350 сая ам.долларын өртэй байв. Үнэндээ өр барагдуулах явц 6 жил сунжирсан ч, өнгөрөгч онд өрийн үлдэгдэл болох 30 хувийг 7 сарын хугацаанд буюу 2017 оны гуравдугаар сарын 30-нд бүрэн барагдуулав.

Мөн “Эрдэнэс-Таван толгой” ХК Төлөөлөн Удирдах Зөвлөлийнхөө шийдвэрийн дагуу Хөгжлийн банкнаас олгосон 200 сая ам.долларын зээлээс 100 сая ам.долларыг зээлийн эргэн төлөлтийг хуваарьт хугацаанаас нь өмнө буюу 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдөр төлсөн бол энэ оны хоёрдугаар сарын 28-нд 50 сая ам.долларыг төлжээ.

Харин энэ сарын 27-ны өдөр үлдсэн 50 сая ам.долларын үндсэн зээлийг төлөх шийдвэр гаргаснаар “Эрдэнэс-Таван толгой” ХК Хөгжлийн банкны 200 сая ам.долларын зээлийн үндсэн төлбөрийг барагдуулахаар болж байна.

Дээрх 200 сая ам.долларын зээлийг “Эрдэнэс-Таван толгой” ХК-д Засгийн Газрын 2012 оны шийдвэрээр “Хүний Хөгжил сан”-гаар дамжуулж иргэн бүрт олгосон халамжийн мөнгөний тодорхой хэсгийг бүрдүүлэх, компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор олгожээ.

Эх сурвалж: Montsame.mn

БУСАД МЭДЭЭ

АНУ: БНХАУ-тай худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээ хийж байна

АНУ болон БНХАУ худалдаа, хөрөнгө оруулалтын яриа хэлэлцээ хийж байгаа талаар АНУ-ын засаг захиргаа мэдээллээ. Ням гарагт АНУ-ын Сангийн сайд Стивен Мнучин “БНХАУ-ын талтай үр дүнтэй харилцан яриа өрнүүлсэн”-ээ мэдэгджээ. Энэ үеэр талууд худалдааны алдагдлыг бууруулах, БНХАУ-д үйл ажиллагаа явуулж байгаа АНУ-ын компаниудын өмнө тулгарсан асуудлуудыг шийдвэрлэх чиглэлд санал солилцсон байна. Үүнээс гадна Дональд Трампын засаг захиргаа АНУ-ын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд зах зээлээ нээлттэй болгохыг БНХАУ-аас хүсэж байгаа гэж ойрын эх сурвалж мэдээллээ. Мөн БНХАУ-д экспортолж буй автомашины татварыг бууруулах санал тавьсан байна. Түүнчлэн АНУ-ын Төрийн тэргүүн худалдааны алдагдлаа 100 тэрбум ам.доллараар бууруулахыг БНХАУ-аас хүсэж байгаа талаар Цагаан ордны Худалдааны зөвлөх Питер Наварро мэдэгджээ. Тэрбээр “Хүн бүр худалдааны дайны талаар ярьж, асуудлыг хурцатгаж байгаагаа зогсоох ёстой” гэж байр сууриа илэрхийлсэн байна. Өнгөрсөн онд АНУ БНХАУ-тай хийсэн худалдаанаас 375 тэрбум ам.долларын алдагдал хүлээсэн нь түүхэн дээд үзүүлэлт болжээ.

Үүнээс гадна БНХАУ-ын тал ган, хөнгөн цагааны импортын татвараас хүлээх алдагдалд нөхөн олговор олгохыг АНУ-аас хүссэн гэж эх сурвалжууд мэдээлж байна.

АНУ БНХАУ-ын компаниудын технологийн салбарын хөрөнгө оруулалтыг хязгаарлахаар төлөвлөж байна

Дональд Трампын Засаг захиргаа АНУ-ын технологийн салбар дахь БНХАУ-ын хөрөнгө оруулалтыг хязгаарлахаар төлөвлөж байгаа талаар эх сурвалж мэдээллээ. Тодруулбал, АНУ-ын Сангийн яамны албаныхан БНХАУ-ын компаниудын технологийн салбарын хөрөнгө оруулалтад хориг тавихаар ажиллаж байгаа юм байна. Ойрын эх сурвалжуудын мэдээлснээр энэ шийдвэр хагас дамжуулагч үйлдвэрлэгч болон 5G технологийн харилцаа холбооны компаниудыг хамарч магадгүй байна. АНУ-ын Худалдааны сайд Уилбур Росс “Гадаадын хөрөнгө оруулалтад хязгаарлалт тогтоон” гэдгийг мэдэгджээ. Харин БНХАУ АНУ-ын худалдааны бодлогын хариуд маргаан, санал зөрөлдөөнтэй байдлыг яриа хэлэлцээрийн замаар шийдвэрлэх хэрэгтэй гэсэн байр сууриа дахин нэг удаа бататгажээ. Үүнээс гадна БНХАУ зах зээлээ илүү нээлттэй болгоход чиглэсэн шинэчлэлээ өргөжүүлнэ гэдгийг тус улсын Гадаад хэргийн яам онцолсон байна.

БНХАУ-ын Гадаад хэргийн яамны хэвлэлийн төлөөлөгч Хуа Чунинь “Яриа хэлэлцээ хийх, зөвлөлдөх үүд хаалга үргэлж нээлттэй байх болно. Гэхдээ хэлэлцээ нь аль нэг тал шаардлагаа хэт өндөрсгөж, нөгөө талд саад учруулах талаар байх ёсгүй гэдгийг энд онцолмоор байна. Тиймээс яриа хэлэлцээ талуудын ашиг сонирхлыг хангасан, харилцан эрх тэгш байх ёстой гэж бид үзэж байна. Ингэснээр бид аль аль талдаа харилцан ашигтай үр дүнд хүрэх болно” гэж мэдэгдсэн байна. Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ өсгөсний дараа БНХАУ-ын Төв банк мөнгөний бодлогоо чангатгах алхам хийлээ. БНХАУ-ын Ардын банк арилжааны банкнуудад олгодог богино хугацаатай зээлийн хүүгээ таван суурь нэгжээр нэмэгдүүлсэн байна. Ийнхүү БНХАУ-ын Төв банкны шинэ тэргүүн И Ган томилогдсоноосоо хойших анхны шийдвэрээ гаргалаа. Тэрбээр “Цаашид мөнгөний хянамгай бодлого баримтална” гэдгээ мэдэгдээд байгаа юм.

Эх сурвалж: BloombergTV.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдлаар баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.